

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2011 оны 12 сарын 14-ны өдөр

Дугаар 417/248

Улаанбаатар хот

**Зардлын жишиг тогтоох тухай**


Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 6 дах заалтыг үндэслэн  
ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох мэргэшлийн шалгалт өгөхөд нэг мэргэжилтнээс авах төлбөрийг 12000 төгрөгөөр, шалгалтын үйл ажиллагааны зардлын дээд хэмжээг шалгалтын комиссын гишүүд, мэргэжлийн багш нарт гэрээний үндсэн дээр 5000-12000 төгрөгийг хүн/цагаар тооцож олгосугай.

2. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Хүрэлбаатар), Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Баттөр) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын байнгын хэрэгжилтийг хангаж ажиллах, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох үйл ажиллагааны нийт зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэхгүй байхыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар (Ш.Энхбат)-т үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД



С.ЛАМБАА

САНГИЙН САЙД



С.БАЯРЦОГТ